



**Үндэсний Аудитын газрын харъяа
Хэнтий аймгийн Аудитын газар**

Аудитын тайлан

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2016 ОНЫ
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
ҮАГ-НАГ/2016/07-НА-ХЭ**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА	ХУУДАС
	Товчилсон үгийн тайлбар	2
Хэнтий аймгийн аудитын газар Аймгийн тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин Аудитын менежер Б.Наранцэцэг Ахлах аудитор Н.Туяа	ТАНИЛЦУУЛГА	3
	Аймгийн Сонгуулийн хорооны талаарх товч танилцуулга	3
	Гүйцэтгэлийн аудит хийх болсон шалтгаан	3
	АУДИТ ХИЙГДСЭН ТУХАЙ	
	Аудитын зорилго	3
	Аудитын цар хүрээ	3
	Аудитад ашигласан арга аргачлал	4
	Эрсдлийн үнэлгээ	4
	Аудитын гол ба дэд асуудлууд,	
	АУДИТЫН ГОЛ АСУУДЛУУД БА ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛС	
2016 оны 11 дүгээр сар	Бүлэг 1: Сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх	5-6
	1.1. Сонгуулийн зардлыг хэсгийн хороодод батлагдсан заавар журмын дагуу бодитой тооцож хуваарилсан байна.	5
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7056-2147 дугаарын утас, 7056 -2112 дугаарын факсаар харилцана уу	1.2. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.	6
	Бүлэг 2: Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх	6-7
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 3 давхар, 315 тоот	2.1 Сумын ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлсэн байна.	6-7
	2.2 Сонгуулийн зардлаар бэлтгэсэн бараа материалыг сонгууль дууссаны дараа данс бүртгэлд тусгаагүй байгаа нь бараа материал үрэгдэх шамшигдах нөхцөл бүрдэж, сумдын сонгуулийн хороо дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.	7
	НЭГДСЭН ДҮГНЭЛТ БА ҮНЭЛГЭЭ	7
	ЗӨВЛӨМЖ БА УДИРДЛАГЫН ТАЙЛБАР	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	9
	Саналд өгсөн тайлбар	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн Газар
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ЗГ	Засгийн Газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МТБ	Мэдээлэл технологийн баг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

ТАНИЛЦУУЛГА

Аймгийн Сонгуулийн хорооны талаарх товч танилцуулга

Хэнтий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн 01 тоот тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүн, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар томилсон байна.

Сумын ИТХ-ын 2016 оны сонгуульд Хэнтий аймгийн Сонгуулийн хороо, 18 сумын сонгуулийн 91 хэсгийн хороо, санал авах байр байгуулагдан, тэдгээрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч 556, мэдээллийн технологийн багийн 114 ажилтан нийт 670 албан хаагч ажилласан байна.

Сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулах Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардалд СЕХ-ноос 319.3 сая төгрөгийн санхүүжилт ирүүлсэн байна.

Хэрлэн сумын Тахилгат тосгонд нэмэлт санал хураалт 10 дугаар сарын 23-ны өдөр явагдаж, Дархан, Галшар, Баянхутаг сумдад тус бүр нэг хэсэг дээр дахин санал хураалт явагдсантай холбогдон дээрхи сумд, аймгийн Сонгуулийн хороонд шаардлагатай байсан 3.0 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэх эрхийг Сонгуулийн ерөнхий хорооноос авч зарцуулан, сонгууль амжилттай зохион байгуулагдсан байна.

Сумын ИТХ-ын 2016 оны сонгуульд тус аймгаас санал өгөх 46713 сонгогч нэрийн жагсаалтанд бичигдснээс 29974 сонгогч буюу 64.2 хувь нь саналаа өгсөн байна.

Сумын ИТХ-ын 376 төлөөлөгчид МАН 211, АН 159, ИЗНН 1, бие даан нэр дэвшигч 5 сонгогдсон байна. Үүнээс 247 эрэгтэй, 129 эмэгтэй төлөөлөгч сонгогджээ.

Нийцлийн аудит хийх болсон үндэслэл

Хэнтий аймгийн Аудитын газар нь УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.15 заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд “Сумын ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д нийцлийн аудит хийлээ.

АУДИТ ХИЙГДСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Аудитын зорилго

Нийцлийн аудитын зорилго нь сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулж, явуулах үйл ажиллагааны санхүүжилтэд төсвөөс олгосон хөрөнгийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ҮАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ-д танилцуулахад чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

1. Сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх
2. Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

Аудитын хамрах хүрээ

Сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардалд төсвөөс олгохоор батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн Сонгуулийн хороо, 18 сумын сонгуулийн хорооны анхан шатны баримт, төсөв, гүйцэтгэлийн мэдээ холбогдох бусад баримт материалуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан арга зүй

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ АДБОУС, Нийцлийн аудитын гарын авлагууд болон журам, ажил гүйлгээг анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авах, тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Эрсдлийн үнэлгээ

Эрсдлийн үнэлгээг “Дунд” гэж үнэлсэн

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа ба бүрэлдэхүүн

Аудитыг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд ахлах аудитор Н.Туяа хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл ба Бэрхшээл

Аймгийн Сонгуулийн хороо нь сонгууль дууссанаас хойш сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг Сонгуулийн ерөнхий хороонд 30 хоногийн дотор тушаах журамтай.

18 сумын сонгуулийн хороо, аймгийн сонгуулийн хороо нийт 19 сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг нягтлан шалгахад хүн хүч, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал, аудитын ахлах аудитор Н.Туяа ганцаараа гүйцэтгэсэн болно.

АУДИТЫН ГОЛ АСУУДЛУУД БА ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛ

БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН, ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСЭН ЭСЭХ

1.1 Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэх

Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд СЕХ-ноос 319.3 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилан шилжүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын хэсгийн хороо, байршил, хүн амын тооноос хамааруулан СЕХ-ноос гаргасан заавар журмын дагуу зардал тус бүрээр төсөв хуваарилсан байна. Хуваарилсан төсвийн дагуу 2016 оны 09 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд нийт 4 удаагийн санхүүжилтээр 279.1 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороодод хуваарилаж олгосон байна.

СЕХ-ноос олгосон санхүүжилтийг аймаг болон сумдын Сонгуулийн хороонд хуваарилсан байдлыг диаграмаар харуулбал:

/мян.төг/



Дээрх диаграмаас харахад аймгийн Сонгуулийн хороонд 40.2 сая төгрөг буюу 12.6 хувийг, Хэрлэн сумын сонгуулийн хороо 28.3 сая төгрөг буюу 8.9 хувийг, Өмнөдэлгэр сумын сонгуулийн хороо 20.2 сая төгрөг буюу 6.3 хувийг, Батноров сумын сонгуулийн хороо 20.2 сая төгрөг буюу 6.3 хувийг, Галшар сумын сонгуулийн хороо 18.4 сая төгрөг буюу 5.8 хувийг, үлдсэн 233.2 сая төгрөг буюу 66.4 хувийг сумдын сонгуулийн хороодод хуваарилан санхүүжүүлжээ.

СЕХ-ноос баталсан төсвийг дахин санал хураалт зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос авсан зөвшөөрлийн дагуу саналын хуудас авах зардлыг 0.3 сая төгрөгөөр, болзошгүй зардлыг 0.4 сая төгрөгөөр, сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, сонгуулийн автомат машиныг хүлээн авах, өгөх зардлыг 0.9 сая төгрөгөөр, эрчим хүчний эх үүсвэрийн зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус бууруулан 1.3 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлсэн байна.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Аймгийн болон сумдын Сонгуулийн хороо нь хуваарилсан төсвийн дагуу санхүүжилтээ бүрэн авч, зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилалын дагуу гаргаж ирүүлсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгахад сумын ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах зардлын 313.6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахдаа зохих ёсоор анхан шатны баримтыг бүрдүүлэн, батлагдсан төсвийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардал нийт дүнгээрээ хэтрээгүй бөгөөд зардлын хэмнэлт 5.7 сая төгрөгийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

Үүний 2.1 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны дансанд сумдын сонгуулийн хорооноос буцаан төвлөрүүлсэн бол 3.6 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны зардлын хэмнэлт байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнг шинжлэн дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Сонгуулийн зардлыг хэсгийн хороодод батлагдсан заавар журмын дагуу бодитой тооцож хуваарилсан байна.
2. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

БҮЛЭГ 2: ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

2.1 Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэх

Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардалд нийт 319.3 сая төгрөг батлагдснаас гүйцэтгэлээр 313.6 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 5.7 мянган төгрөгийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлжээ.

Сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэл

				/мян.төг/
№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350.0	350.0	-
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	1,800.0	1,800.0	-
3	Сургалтын зардал	12,478.0	12,173.8	304.2
4	Бичиг хэргийн зардал	11,380.0	11,359.6	20.4
5	Шуудан холбооны зардал	11,380.0	11,299.1	80.9
6	Унааны зардал	45,125.0	44,731.1	393.9
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	8,000.0	8,000.0	-
8	Санал авах байр бэлтгэх зардал	18,200.0	18,059.6	140.4
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	600.0	-
10	Томилолтын зардал	5,266.0	4,348.5	917.5
11	Саналын хуудас авах зардал	6,323.0	5,285.8	1,037.2
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	13,965.0	11,594.9	2,370.1
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	4,060.0	3,988.0	72.0
14	Болзошгүй зардал	5,388.0	5,145.0	243.0

15	Сурталчилгааны материал хүргэх зардал	1,950.0	1,950.0	-
16	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	142,756.4	142,587.9	168.5
17	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал хоолны зардал	30,311.6	30,311.6	-
Нийт дүн		319,333.0	313,584.8	5,748.2

Маягт хэвлүүлэх зардал, төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардал, хууль тогтоомж сурталчлах зардал, МТБ-ийн мэдээ дамжуулах зардал, сурталчилгааны материал хүргэх зардал, МТБ-ийн хоолны зардал, урамшууллын зардлыг төсвийн дагуу зарцуулсан бол бусад зардлыг 20 мянган төгрөгөөс 2.4 сая төгрөгөөр хэмнэжээ.

Сонгуулийн зардлын тайланд нэгтгэгдсэн 18 сумын сонгуулийн зардлын тайлан, аймгийн Сонгуулийн зардлын тайлан, холбогдох анхан шатны баримт, дансны хуулгаар тулган шалгахад сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлсэн байна.

2.1 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх

Аймаг болон сумдын сонгуулийн хороо нь хуваарилсан хөрөнгийг зарцуулж тайлагнасан боловч

- Мөн Батноров сумаас бусад сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороо нь байр тохижуулах зардалд зориулан бэлтгэсэн уртасгагч, гэрлийн утас, хулдаас, галын хор гэх мэт 7.3 сая төгрөгийн зарим бараа материалыг сонгуулийн дараа хаана бүртгэлд авч хүлээн авсан талаар мэдээлэл байхгүй, бүртгэлд тусгаагүй орхигдуулснаас үзэхэд дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитаар сонгуулийн санал авах байр бэлтгэх зардлаас худалдан авсан нийт 7.3 сая төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй, сонгуулийн дараа хаана орлого авсан талаар мэдээлэл тодорхойгүй зөрчлийг илрүүлж, үүнээс аудитын явцад үлдэгдэл 1.7 сая төгрөгийн бараа материалыг сумын ЗДТГ, ИТХ, төсөвт байгууллагад орлого авахуулан, зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажиллалаа.

Дүгнэлт

Дээрх зөрчил гарсан шалтгаан, үр дагаварыг шинжлэн дараах дүгнэлтэд хүрч байна.

- Сумын ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлсэн байна.
- Сонгуулийн зардлаар бэлтгэсэн бараа материалыг сонгууль дууссаны дараа данс бүртгэлд тусгаагүй байгаа нь бараа материал үрэгдэх шамшигдах нөхцөл бүрдэж, сумдын сонгуулийн хороо дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ БА ҮНЭЛГЭЭ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Сонгуулийн зардлыг заавар журмын дагуу тооцон хуваарилан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зардлын гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлсэн боловч бэлтгэсэн хөрөнгийг бүртгэлд орлого авахуулахад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумын Сонгуулийн хороонд

1. Сонгуулийн зардлаас бэлтгэгдсэн бараа материалыг сонгуулийн дараа комисс томилон төсөвт байгууллагын данс бүртгэлд бүртгэж , орлого авч байх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН САНАЛ БА ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1 дах хэсэгт заасны дагуу нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар аймгийн Аудитын газрын 2016 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 285 тоот албан бичгээр Аймгийн Сонгуулийн хорооны удирдлагад хүргүүлсэнд хариуг 2016 оны 12 дугаар сарын 01 –ны 123 тоот албан бичгээр ирүүлсэн байна.


**ХЭНТИЙ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
23118 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас, Факс: 70-55-23-07

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2016.12.01 № 123
танай _____-ны № _____-т

Тайлангийн төслийг хүлээн
зөвшөөрөх тухай

Аймгийн Аудитын газрын 2016 оны ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу
"Сумын ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тайланд тусгагдсан асуудлуудыг
хүлээн зөвшөөрч байгаа болно.


ДАРГА  Ж. ГАНБААТАР

Аудитын тайлан бичсэн:
Ахлах аудитор

Н.Туяа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 236

Өндөрхаан

Г

Г

Нийцлийн аудитын тайланг
батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан "Нийслэл болон аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, Гүйцэтгэлийн аудитын журам-ын 12.40, Чанарын хяналтын журам-ын 5.3.4, аймгийн Аудитын газрын удирдах зөвлөлийн 2016 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН

12000073

